

М.Золзаяа

ХИДС-д тэнхимийн эрхлэгч,  
докторант

**“МАНДАХ НАРНЫ ТУЯА” ХЭМЭЭХ ЗОХИОЛ ДАХЬ  
ЁС ЗҮЙН ЗАРИМ АСУУДАЛ**

Монголчуудын байгуулсан төр улс, соёл цагийн урсгалд янз бүрээр эргэж, нэг мандан, нэг буурч, дахин сэргэх зэргээр хувирал өөрчлөлтийг туулах явцад бидний өвөг дээдэс ёс суртахууны арвин баялаг сургаалыг үлгэр домог, аман зохиол, ардын ёс заншлаараа дамжуулан өвлүүлсээр ирсэн. Монголчуудын ёс суртахууны түүх судлалын эх сурвалж нь билиг зүй, Монголын нууц товчоо, шашны уран зохиолууд, билиг сургаалууд билээ. Үүнээс гадна манай нэрт сэтгэгчдийн зохиол бүтээл дэх ёс суртахууны үнэлэмж, зарчим, хэм хэмжээний талаарх үзэл санаа, ухаалаг сургамжийг шинжлэн судлах шаардлагатай байгаа юм.

ХХ зууны эхэн үеийн Монголын тэргүүний сэхээтэн, шинжлэх ухааны зүтгэлтэн Ч.Бат-Очирын зохиол, бүтээлтэй танилцаж тухайн үед шинэ нийгмийн ухамсар бүрэлдэхэд оруулсан хувь нэмрийг үнэлж дүгнэх нь зөв гэж үзлээ. Энэ хүний зарим зохиол бүтээлийн тухай мэдээлэл төдий байгаа нь учир дутагдалтай, харин үнэлэлт дүгнэлт өгөх, шинжлэх ухааны судалгааны түвшинд авч үзэх нь чухал байна. Юуны өмнө түүний намтраас товч сөхье.

Чулууны Бат-Очир 1927 онд бичсэн өөрийн намтартаа: 1874 онд төрсөн, үндсэн захиргаа Хан хэнтий уулын аймгийн Өндөр хаан уулын хошууны Хэрээ хөхөл /Одоогийн Баянмөнх сум/, нэгдүгээр багийн нэгдүгээр арван, өрх 4, амбул 19, хөдөө гэрт 280 бодтой хэмээн бичжээ. Тэрээр ардын хувьсалаас өмнө шашин төрд туслах яам, хууль цаазны бичиг зохиох газарт бичгийн ба туслах тушмэлийн алба хашиж байсан. Ардын засаг мандснаас хойш Гадаад яаманд туслах тушмэл, бага сургуулийн багш, Судар бичгийн хүрээлэнгийн гишүүн зэргээр ажиллаж явсан. Манж, төвд, хятад хэл бичиг, монгол бичиг мэддэг байсан. 1921 оноос О.Жамъян гүн, Дашиям гүн, Ж.Цэвээн нарын хамт Монголын шинжлэх ухааны тулгын чулуу болсон судар бичгийн хүрээлэнг байгуулсан.<sup>1</sup> Түүхч, манжич эрдэмтэн маань “Монгол улсын эртнээс инагш уламжлан ирснийг товчлон тэмдэглэсэн бичиг хэмээх түүхийн зохиол”, “Монгол үгийн тайлбар толь”, “Мандах нарны туяа” хэмээх шинэхэн хөвгүүдийн оюуны амыг нээх бичиг, “Холбоо найруулал” хэмээх 6 ангит 2206 шад мөр бүхий шүлэг бичжээ<sup>2</sup>.

Эл бүтээлүүдээс 1926 онд бичсэн “Мандах нарны туяа хэмээх сургаалын” зохиол нь бидний сонирхлыг татсан юм. Тэрбээр уг

<sup>1</sup> Ч.Бат-Очир. Мандах нарны туяа хэмээх сургаал. УБ., 1992. 2-р тал

<sup>2</sup> Нэрт монгол хүмүүсийн намтын ойллого. УБ., 2000. 49-р тал.

бичгийн оршилдоо “....хөвгүүд дүү нар бичгийн эрдэм соёлыг урьтал болговол зохихын тулд мунхаг хүдхийг бодохгүй, эртний эрдэмтний зохиосон бага суртахуй бичиг<sup>1</sup> / Күнзийн зохиол мөн гэж зарим судлаач тайлбарладаг/, зургаан хэргийн цээрлэл үгний бичиг, судар шастир, жич аль хэрэгтэй бичиг дүрмүүдээс чухал хэрэглэгдэх үгсийг хураамжлан нэгэн дэвтэр 52 зүйл болгон мандах нарны туяа хэмээн нэрийдэв<sup>2</sup> гэжээ. Түүхэн онцлог энэ үед ёс суртахууны асуудлыг улам бүр нарийвчлан сургаал - сурах бичиг маягаар олны хүртээл болгох шаардлага байгааг зохиогч соргог мэдэrsэн төдийгүй “モンゴлчууд бичиг үсэг сурч эхэлмэгц нь үр хүүхэд шавь нартаа юун түрүүнд Оюун түлхүүр, Чингис хааны билиг сургаал зэргийг уншуулан ёс суртахууны хүмүүжил олгох замаар ертөнцийн ёсыг ухварлуулаад дараа нь номын ёсонд сургадаг<sup>3</sup> монгол уламжлалаа харгалзсан байна. Тусгаар тогтолцоо олж авсан төр улсын нийгмийн харилцаанд ёс суртахууны хэм хэмжээ, зарчмыг баримталдаг иргэн төлөвших бэлгэдэл болгож “мандах нарны туяа” хэмээсэн болов уу. Түүний уг зохиол нь олон янзын бүтээлээс хураангуйлан цуглуулсан бус зохиогч дээр дурьдсан зохиолуудаас ишлэл, санаа сэдэл аван өөрийн холч ухаан, үзэл санаагаа яруу утгаар гүн гүнзгий тусгасан нь судалгааны явцад ажиглагдлаа. Зохиолын “Хүн болж төрөх” хэмээх 1-р зүйлийн ... Эх болсон хүн арван сар болтол шаналан тээж, ганц биед зовлонг хүлээн тэсвэрлэж, аминд хүрэхээр зовж сая нярайлна гэсэн хэсэг нь “Эхийн ачийг хариулсан залбирал” судраас ишилжээ<sup>4</sup>. Мөн “Архи дарс” хэмээх 35-р зүйлийн ... архи нь бат үгсийг задруулдаг, бардам дээрэнгүйг төрүүлдэг, чухал үгсийг цуцалдаг гэх зэргээр Чингисийн есөн өрлөгтэй өнчин хөвгүүний цэцэлсэн шастираас<sup>5</sup> оруулсан бол “Улс төр” хэмээх 8-р зүйлийн ..Дээдэс нь дордсыг энэрэх, дордос нь дээдсээ хүндэтгэх гэсэн нь “Оюун түлхүүр” нэрт шастираас<sup>6</sup> тус тус ишилжээ. Тухайлбал эртний хятадын бичгийн их сэтгэгч Күнзийн “Бага суртахуй” хэмээх нэрт нийгэм -ёс зүйн сурах бичгээс зохиогч сургуулийг бадруулах, гол ёсыг тодорхойлохыг магадласан нь, биеийг хичээнгүйлэхийг тус тус магадалсан нь зэрэг цөөн нэр томъёог авч монгол хүний орчин, сэтгэлзүйд тохируулан баяжуулж бичсэн байна. Мандах нарны туяа зохиолын 14, 45, 47, 48-р зүйлийн нэр, агуулга “Бага суртахуй бичгийн” 7-12 р дэвтэрт байгаа юм. Энэ бол Энэтхэг, ер дорно дахины улс үндэстний хүмүүнлэгийн шинжтэй ёс зүйн дэвшилт уламжлал, номын мэргэдийн хурц гүнзгий, оломгой мэргэн, оновчтой, цэцэн санааг монгол ахуй, сэтгэлгээ, зан заншил, ардын

<sup>1</sup> Бага суртахуй бичиг. /гар бичмэл моогол бичгээр/ УТНС-д буй.

<sup>2</sup> Мандах нарны туяа. /Гар бичмэлийн эхээс/ УБ.,1926.

<sup>3</sup> Л.Хүрэлбаатар. Энэтхэг, Төвд, Монгол сургаалийн зохиолын хэлхээ холбоо. /Хэл зохиол судлал/ УБ.,1987. 217-р тал.

<sup>4</sup> Ц.Дамдинсүрэн. Зуун билиг оршвой. УБ.,1959. 575-р тал.

<sup>5</sup> Мөн зохиолд.

<sup>6</sup> Оюун түлхүүр нэрт шастир. УБ.,2002. 27-р тал

билгийн өвөрмөц хөрсөн дээр хөгжүүлэн, эхнэр хатадын явдал мөрийг заасан ерийн ахуйн сурх бичиг, зан харьцааны билиг сургаал болтол нээж чадсан юм гэж доктор Л.Хүрэлбаатар үнэлжээ<sup>1</sup>. Зохиогч өөрөө уран зохиолын маш их авьяастай, билиг ухаантай хүн байсан нь түүний "Холбоо найруулга" хэмээх зургаан ангит утга яруу шүлгээс нь харагддаг<sup>2</sup>.

Мандах нарны туяа сургаалд ёс суртахууны хэм хэмжээ, зарчим, ухагдахууныг агуулсан байхыг үзэхүл эн нь ХХ зууны эхэн үеийн нийгмийн амьдралын хэрэгцээ шаардлагыг дагалдан гарсан нийгэм улс төрийн, ёс зүйн сургаал гэж тодорхойлогдох юм. Тухайлбал ёс зүйн үндсэн ойлголт, үнэлэмжийг агуулсан "эцэг эхийн ачийг дуртгах" хэмээх 3-р зүйл, "ахчлах дүүчлэх" хэмээх 4-р зүйл, "төрөл төрөгсөд" хэмээх 5-р зүйл, "сэтгэлээр хүндэтгэх хэмээх" 24-р зүйл, "сайн явдал" "муу явдал" 25,26-р зүйл, "Айл гэрт нөхөрлөх" 27-р зүйл, "эдийг арвилах" 30-р зүйл, "ур хилэн" хэмээх 34-р зүйл, "самуун өнгө" хэмээх 37-р зүйл, "нөхрийн явдал" хэмээх 38-р зүйл, "биенгийг хичээнгүйлэх" 45-р зүйл, "байдал янз" 46-р зүйл, "гол ёсыг тодорхойлох" 48-р зүйл, "бүгд шүүмжлэх" хэмээх 52-р зүйлүүдэд юуны түрүүнд бие хүний зан суртахууны эгэл хэм хэмжээ, хүнлэг энэрэнгүй, хамтаж, хөдөлмөрч хичээнгүй байх зарчмуудыг түлхүү авч үзсэн нь ажиглагддаг. Ёс зүйн ухааны үндсэн категори болох сайн ба муу, шудартын тухай тус тусд нь зүйлчлэн тодорхой тайлбарласан. Сайн нь "төрөлх сүлдэл, барилдлага, хувь зохиолтой, мэдэлтэй, оюунтай, шударга агуу, талбиу, дэлгүү, амарлангуй яруу, арга бодлоготой, эрдэм чадалтай, элэгсэг найртай, баатар идтэй, хичээнгүй болгоомжтой, нигүүлсэл өршөөлтэй байх" гэжээ /25-р зүйл/. Муу нь "хэт бүрэлгэгч, омгорхог бардам, долгин балмад, үхээнц дорой, тэнэг мунхаг, хатуу догшин, залхуу бултаач, осол цалгар, залхай гажуу, ховч бялдууч, муу харгис, ховдог авилгач" шинжүүдтэй байна /26-р зүйл/. Харин шударга нь "Голч чигч, цэвэр ичимтгий, өмөөрөх хэлбэрэхгүй, гоёч өргүүгүй /хэлбүүргүй зантай, ураг төрөлд элэгсэхгүй, тоомсоргүй/, ховдог авилгачгүй, ариун нүүртэй" байх явдал юм /25-р зүйл/. Хүн болж төрөөд шударга журмыг дээдлэн, сэтгэл ухаанаа зөв жолоодож явахыг эрхэмлэхэд "хүнд зан суртахууны арван хүндлэл байхаас гадна, хүний алдаа таван зүйлээр байдаг /47-р зүйл/ хүнд нэмэгдэх нөхөр гурав, хорогдох нөхөр гурав, хүний цээрлэл гурав бий, хүнд зургаан зүйлийн халаглал, ёс суртахууны дөрвөн үүсгэл бий" хэмээсэн. Энэхүү дөрвөн үүсгэлд энэрэн өршөөх сэтгэл нь өршөөлийн үүсгэл, ичих жигших сэтгэл нь журмын үүсгэл, маргах найр тавих сэтгэл ёслолын үүсгэл, зөвшөөх буруушаах сэтгэл мэргэний үүсгэл буй гэсэн нь ёс суртахуунд сэтгэлзүйн хүчин зүйл чухал нөлөөтэйг тодорхойлжээ. Мөн зохиолд "самуун өнгө, хурьцангуй дуу хөгжимд

<sup>1</sup> Л.Хүрэлбаатар. Судар шастирын билиг. УБ.,2002. 180-р тал

<sup>2</sup> Чу.Бат-Очир. Холбоо найруулга. УТНС-д буй гар бичимэл эх /монгол бичгээр/

залуус ард эрхгүй дурлахын тул биеийг сээрэмжлэн, явдлыг шинжилж явбал, хол ойрын хүмүүст доромжлогдох элэглэлээс хэлтэрвэл болмуй. Иймийн тул биеийг сахиж, журмыг эрхэмлэн, ариун цэврээр явбал улс төрийн ёслол, нөхөр, гэргийн найртайг бататган олон түмэнд **томуо бүхий хүн хэмээн сайшаагдмуй**" хэмээн залуучуудад сургасан. "Хүмүүний гурван цээрлэл нь залуугийн цагт цусан амьсгал /шинж төлөв/ тогтоогүйн тулд өнгөнд цээрлэмүй, идэршсний хойно цусан амьсгал хараахан хүчирхэгийн тулд хэрүүлд цээрлэмүй, хөгширсөний хойно цусан амьсгал буурсны тулд олохуйд цээрлэмүй" /51-р зүйл/ хэмээн хүний нас сэтгэлзүйн онцлогт тохирсон хэм хэмжээ, цээрлэлийг авч үзсэн. Ерөөсөө монгол угсаатны цээрлэх ёс нь ёс суртахууны хэм хэмжээний диспозицийн агуулгатай зүйл гэж үзмээр байдаг. Энэ зохиол бүхэлдээ хүн ахан дүүс, төрөл төрөгсөд дунд биеz яаж авч явах хийгээд, нийгэм төрд хүчин зүтгэж олон талын харилцаанд ороход эрхэмлэх, цээрлэх, жигших, эвсэх ёс сургаалыг номлосон хэрэг болно.

Эндээс XX зууны эхэн үед монголын ард түмний нийгэм, зан суртахууны хэм хэмжээг зохистой түвшинд байлгах гэж тэргүүний сэхээтнүүд хүсэмжилж байсныг ч тодорхой мэдэж болно. Тус зохиолын агуулгад уламжлалт хэв хууль, билиг сургаал, ёс заншил, Күнзийн сургаал, буддын ёс суртахууны сургаал, дөнгөж орж ирээд байсан марксист үзэл суртал зэргийн нелөө аль аль нь илэрч байна. Тэрээр нийгмийн амьдралын олон хүрээ салбар болох улс төр, хууль эрх зүй, шашин, эрүүлийг хамгаалах, боловсрол, соёл шинжлэх ухаан, худалдаа, цэрэг, хөдөө аж ахуй, газар тариалан зэргийн зорилго, чиг үүрэг, зохион байгуулалт, дэг журмыг энгийн ойлгомжтой илэрхийлэхийн хамт тэдний эрх, ашиг сонирхлын тухай цогцоор өгүүлжээ. Тухайлбал "Сургууль хэмээгч хүнийг эрдмээр хүмүүжүүлж, мунхгийг арилгаж сайнд удирдан, хэв хуулийг дагуулан, цэцэн, мунхаг, идэрхэг, доройг нийтээр нэгэн мөр болгосугай хэмээх нь буюу. Бичгийн хүнийг дөрвөн зүйлийн иргэний тэргүүн хэмээх тул бичгийн ард биеийг хөнгөн болговоос үл болмуй /3-р зүйл/ ғэсэн бол **Аливаа сургагч нар** /Багш М.З/ "санаа шимтэж сургахаас гадна занчих цохихыг хэрэглэхгүй, зөөлөн авир, эелдэг аашаар урамшуулан хөгжүүлж, идэх уух, дуулах, хөгжимдөх, тоглох наадах, сонин зураг үзүүлэх зэргээр уйтгарыг сэргээж, хааяа нэгэн бие залхаах зөөлөн сэтгэлээр айлгаж сургавал баярлах, хашрах нь хамтаар ирж, мууг тэвчих, сурахуйд дурлах, улмаар шимтэл орж оюун нээгдэх нь магад" гэж багшийн сурган хүмүүжүүлэх ёс зүйн хэм хэмжээ, сургах арга барилын тухай өгүүлсэн байна /15-р зүйл/. Энэ нь XIX зууны ерөнхий дидактикийн онолын үзэл санааг үндсэнд нь тусгасан гэхээр байна. Эл учрын үүднээс, эдүгээ бидний үед уламжилж ирсэн "мандах нарны туяа" сургаалын зохиолын агуулгаас XX зууны эхэн үеийн ёс суртахууны зарчим, үнэлэмжийн баримжааллыг тодруулах боломжтой юм.

*Some issues of ethics in the work "Mandakh narani tuya"*

### Summary

It is proper that analyse ethically a teaching work "Mandakh narani tuya" by Bat-Ochir.T a figure in science, and evaluate his contribution to the Mongols social consciousness. "Mandakh narani tuya" is the ethical, social and political teaching work with 52 points.

### Ном зүй:

1. Ч.Бат-Очир. Мандах нарны туяа хэмээх сургаал. УБ.,1992
2. Чу.Бат-Очир. Мандах нарны туяа хэмээх сургаал. УБ.,1926  
/Гар бичмэл УТНС-д буй /
  3. Чу.Бат-Очир. Холбоо найруулга гар бичмэл эхээс УТНС-д буй
  4. Бага суртахай бичиг /УТНС-д буй монгол бичгээр/
  5. Нэрт монгол хүмүүсийн намтрын ойллого. УБ. ,2000
  6. Оюун түлхүүр нэрт шастир. УБ.,2002
  7. Л.Хүрэлбаатар. Судар шастирын билиг. УБ.,2002
  8. Хэл зохиол судлал УБ.,1987
  9. Ц.Дамдинсүрэн. Зуун билиг оршвой. УБ.,1959